## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН 2024-2028 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ 2025 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ХЭРЭГЖИЛТ

2025 оны 12 дугаар сарын 01 | Улаанбаатар хот

| Д/д | Зорилго | Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан зорилт | № | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт, хэмжих нэгж | Суурь түвшин 2023 | Зорилтот түвшин | Хүрсэн түвшин | Гүйцэт-гэлийн хувь | Арга хэмжээний хэрэгжилт | Арга хэм-жээний гүйцэтгэ-лийн хувь | Батлагд-сан төсөв /сая төгрөг/ | Батлагд-сан эх үүсвэр | Санхүүжил-тийн гүйцэтгэл сая төгрөг | Санхүүжил-тийн эх үүсвэр | Хариуцах газар |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 | 10 | 11 | 12 | 13 | 14 | 15 | 16 | 17 |
| **НЭГ.БҮСЧИЛСЭН ХӨГЖЛИЙН БОДЛОГО** | | | | | | | | | | | | | | | | |
| 5 | 1.1.1. Хот төлөвлөлт, засаглалын шинэчлэл | 1.1.1.2.Хот төлөвлөлт, орчны стандарт алдагдсан орон сууцны хорооллуудад газар чөлөөлөлт хийж, орчны төлөвлөлтийг стандартад нийцүүлнэ. | 5 | Орон сууцны хорооллуудад хот байгуулалт, барилгын хяналтыг хэрэгжүүлж, төлөвлөлтийг норм, стандартад нийцүүлэх ажлыг зохион байгуулах | Тухайн жилийн арга хэмжээний хэрэгжилт, хувь | - | 100 | 100 | 100% | 1. Хот байгуулалт, барилгын норм, дүрэм зөрчигдсөн асуудлаар холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулж ажиллах зорилгоор нийт 35 мэдэгдлийг Хот байгуулалт, хотын стандартын газарт хүргүүлсэн. Үүнээс 20 мэдэгдэл буюу 57 хувь нь холбогдох норм, дүрэмд нийцүүлэн шийдвэрлэгдсэн бөгөөд 15 мэдэгдэл буюу 43 хувь нь тус байгууллагад судлагдаж байна.<br>2. Хот байгуулалтын тухай хууль, Барилгын тухай хууль, Орон сууцны тухай хууль болон холбогдох норм ба дүрэм зөрсөн нийт 52 зөрчилд шалган шийдвэрлэх ажиллагааг явуулсан. Үүнээс Зөрчлийн хэрэг нээсэн 17, Хялбаршуулсан журмаар шийдвэрлэсэн 32, Хэрэгсэхгүй болгосон 3 хэрэг байна. Зөрчлийн хэрэгт нийт 235.7 сая төгрөгийн торгууль ногдуулж, 138.1 сая төгрөг (58.5%)-ийг бүрэн барагдуулсан.<br>3. Хот төлөвлөлтийн норм ба дүрэм зөрчигдсөн үндэслэлээр иргэн, хуулийн этгээдээс ирүүлсэн хүсэлтийн дагуу барилгын зай хэмжээ хангахгүй 3 дүгнэлт, норм, дүрэм зөрсөн 1 дүгнэлт, ашиглалтын шаардлага хангахгүй 3 дүгнэлт, нийт 7 дүгнэлт гарган хүргүүлсэн | 100% | 0 | 0 | 0 | Санхүүгийн эх үүсвэр батлагдаа-гүй | **НХШГ** |
| 136 | 2.4.3.Нийтийн аж ахуй, инженерийн | 2.4.3.8.Зам, замын байгууламжийг | 469 | Авто зам, замын байгууламжий | Арга хэмжээний | - | 50 | | | Зам, тээврийн хөгжлийн яамны Салбарын улсын ерөнхий байцаагчийн 2025 оны "Урьдчилан | 100% | | | | | |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 | 10 | 11 | 12 | 13 | 14 | 15 | 16 | 17 |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | дэд бүтэц | хотын инженерийн бэлтгэл арга хэмжээний нэгдсэн төлөвлөлттэй уялдуулж, ус зайлуулах шугам сүлжээг барьж байгуулна. | | н төлөвлөлтөөс ашиглалтад оруулах хүртэл хянах, магадлах, батлах, шалгах зэрэг үйл ажиллагаанд мөрддөг хууль, норм, дүрэм, журмыг уялдуулан шинэчилж, хэрэгжүүлэх | хэрэгжилт, хувь | | | | | сэргийлэх шалгалт хийх тухай" 04/05 дугаартай удирдамжийн дагуу дараах төслүүдийн барилга угсралт, орчны аюулгүй байдал, зураг төсөлтэй нийцсэн эсэхэд хяналт шалгалт хийж, илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулах арга хэмжээг авч ажиллав. Үүнд:<br>1) Дүүжин тээврийн төслийн барилга угсралтын ажилд шалгалт хийж, барилгын түр хашаа, орчны аюулгүй байдлыг хангуулах, дутагдлыг арилгуулах талаар гүйцэтгэгч Моннис инженеринг ХХК-д албан шаардлага хүргүүлэв.<br>2) Сонгинохайрхан дүүргийн Соёлын төвийн урд хэсгийн авто замын угсралтын ажлыг шалгаж, батлагдсан зураг төсөл зөрчиж авто замын зорчих хэсгийн цахилгааны тулгуур шилжүүлэхгүйгээр асфальтбетон хучилт хийсэн "Баян-Өлзийт зам" ХХК-д Зөрчлийн тухай хуулийн дагуу торгуулийн арга хэмжээ авч, зөрчил арилгах албан даалгавар хүргүүлэв.<br>3) Баянзүрх дүүрэг Сансарын үйлчилгээний төв орчмын тохижилтын ажлыг шалгаж, илэрсэн дутагдлыг арилгуулахаар гүйцэтгэгч "Морин сувд" ХХК-д албан шаардлага хүргүүлэв.<br>4) Сонгинохайрхан дүүрэг, 27 дугаар хороо, 46 байрны ард авто машины зогсоол шинээр байгуулах ажлын гүйцэтгэлд хяналт шалгалт хийв.<br>5) Баянгол дүүргийн 20 дугаар хорооны нутаг дэвсгэрт байрлах Эрчим хүчний гудамжны авто замын өргөтгөл, шинэчлэлтийн ажлын зураг төсөл, холбогдох баримт бичиг, барилга угсралтын ажлын гүйцэтгэлийг шалгаж, зөвлөмж өгөв. | | | | | | |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 | 10 | 11 | 12 | 13 | 14 | 15 | 16 | 17 |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | | “Авто зам, замын байгууламжийн барилгын ажил эхлүүлэх, үргэлжлүүлэх, ашиглалтад оруулах журам”-ын төсөлд 2 санал боловсруулж хүргүүлсэн. Мөн “Авто зам, замын байгууламжийн зураг төсөл, барилга угсралтын ажилд гардаг нийтлэг зөрчил, дутагдал” сэдвээр 81 захирал, инженер техникийн ажилчдад сургалт зохион байгуулав. | | | | | | |

ХЯНАСАН:
ДОТООД ХЯНАЛТ, ШИНЖИЛГЭЭНИЙ ХЭЛТСИЙН ДАРГА Б.ОЮУНТУЯА

БОЛОВСРУУЛСАН:
ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН БИЕЛЭЛТ, ТАЙЛАН ХАРИУЦСАН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН М.ГАЧМАА